



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 01 өдөр

Дугаар А/581

Номгон

“Хонгорын дуун” утга зохиолын өдөрлөг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, “Аймгийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөний 1.6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баянхонгор аймгийн Баацагаан сумын уугуул Төрийн шагналт зохиолч, яруу найрагч Ч.Лхамсүрэнгийн намтар, уран бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулах, алдаршуулах, шинэ залуу уран бүтээлчдийг тодруулах зорилгоор “Хонгорын дуун” утга зохиолын өдөрлөгийг зохион байгуулсугай.


2.Дээрх өдөрлөгийг зохион явуулах удирдамжийг 1 дүгээр, зардлын тооцоог 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.“Хонгорын дуун” утга зохиолын өдөрлөгийн үйл ажиллагаанд зарцуулагдах 5.000.000 (таван сая) төгрөгийг аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4.“Хонгорын дуун” утга зохиолын өдөрлөгийг удирдлага зохион байгуулалтын өндөр түвшинд, үр дүнтэй зохион байгуулахыг Нийгмийн бодлогын хэлтэс (В.Наранчимэг), Монголын зохиолчдын эвлэлийн Баянхонгор аймаг дахь зохиолчдын холбоо (Б.Жавзандулам) нарт тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642311533

Аймгийн Засаг даргын 2023 оны 11-үгээр сарын
01-ний өдрийн 4/537 дүгээр захирамжийн
1 дүгээр хавсралт

УДИРДАМЖ

“Хонгорын дуун” утга зохиолын өдөрлөг зохион байгуулах

Нэг.Зорилго.

Баянхонгор аймгийн Баацагаан сумын уугуул Төрийн шагналт зохиолч, яруу найрагч Ч.Лхамсүрэнгийн намтар, уран бүтээлийг олон нийтэд сурталчлан таниулах, алдаршуулах, шинэ залуу уран бүтээлчдийг нээн илрүүлж, уран бүтээлээр нь ард иргэдтэй уулзуулах, яруу найргийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дугуйлан, клуб, төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх

Хоёр. Хамрах хүрээ. Яруу найраг сонирхогч ард иргэд, хувь хүмүүс нутаг дэвсгэр, харьяалал харгалзахгүйгээр нээлттэйгээр оролцоно. (16-аас дээш насныхан)

Гурав. Хугацаа. 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр.

Дөрөв. Явагдах үе шат.

Яруу найргийн наадам 4 үе шаттай явагдана.

1-р шат: 1-р шатанд шүлгээ ирүүлсэн яруу найрагчдын шүлгийг хүлээн авч, зохион байгуулагчдын зүгээс шүүн тунгааж, 2-р шатанд оролцох уран бүтээлчдийг шалгаруулна.

2-р шат: 1-р шатнаас шалгарч үлдсэн 35 яруу найрагч өөрийн биеэр оролцож, шүлгээ уншина.

3-р шат: 2-р шатнаас шалгарсан 20 яруу найрагч шүлгээ уншина.

4-р шат: Шилдэг 8 яруу найрагчийн шүлгийг уншуулж, цомын эзнийг тодруулна.

Тав. Шагналын сан:

1-р байр-1 “Хүрэн морь” сийлбэр цом, өргөмжлөл , мөнгөн шагнал (цом-1.000.000, мөнгөн шагнал 500,000 төгрөг)

2-р байр -1 Өргөмжлөл, мөнгөн шагнал 400,000 төгрөг

3-р байр – 1 Өргөмжлөл, мөнгөн шагнал 300,000 төгрөг

4-р байр -1 Өргөмжлөл, мөнгөн шагнал 200,000 төгрөг

5-р байр - 1 Өргөмжлөл, мөнгөн шагнал 150,000 төгрөг

2.

Тусгай байр - 3 Өргөмжлөл мөнгөн шагнал, тус бүр 100,000 төгрөг

Зургаа. Тавигдах шаардлага:

Оролцогчид өөрийн сонгосон чөлөөт сэдвийн дагуу бичсэн 3 хүртэлх уран бүтээл, товч намтраа 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 18.00 цагийн дотор зохион байгуулагчдад ирүүлж бүртгүүлэх бөгөөд, зохион байгуулагчид 2-р шатанд шалгарсан 35-40 уран бүтээлчдийн нэрсийг тодруулан 2023 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 18.00 цагт багтаан цахимд байршуулна.

-Уран бүтээл нь өмнө нь уншигдаагүй шинэ шүлэг байна.

-Шүлгээ агай 12-оор шивсэн байх ба мөр хоорондын зай 1-1.5-аар бичсэн байна.

-Өөрийн овог, нэр, холбоо барих утасны дугаар, хаанаас оролцож буйгаа товч, тодорхой бичсэн байна.

Долоо. Бүртгэл:

Наадмын 2-р шатанд оролцох уран бүтээлчдийг 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 10.00 цагт Нийтийн номын сан дээр бүртгэж, мандат олгон, яруу найргийн наадам 12.00 цагт эхэлнэ. Мандатын үнэ 20,000 төгрөг.

Ес. Шүүлт:

Яруу найргийн наадмыг Монголын Зохиолчдын эвлэл, аймгийн Зохиолчдын холбоо, Нийтийн номын сангийн бүрэлдэхүүн шүүн тунгаана.

Холбоо барих утас: 94957175, 89338202

Имэйл хаяг: tushke_1123@yahoo.com

Жич: Оролцогчид байр, унаа, хоолны зардлаа өөрсдөө хариуцна.

Хамтран зохион байгуулагч:


Баянхонгор аймгийн Соёл, урлагийн газар

Монголын Зохиолчдын эвлэл

Хүүхдийн Тэмүжин театр

_____оОо_____

Аймгийн Засаг даргын 2023 оны 21-үгээр сарын
01-ний өдрийн 4/2021 дүгээр захирамжийн
2 дугаар хавсралт



**“ХОНГОРЫН ДУУН” УТГА ЗОХИОЛЫН ӨДӨРЛӨГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зориулалт	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	“Хүрэн морь” сийлбэр цом	1	1,000,000	1,000,000
2	Тэргүүн байр /мөнгөн шагнал/	1	500,000	500,000
3	Дэд байр /мөнгөн шагнал/	1	400,000	400,000
4	Гутгаар байр /мөнгөн шагнал/	1	300,000	300,000
5	Дөрөвдүгээр байр /мөнгөн шагнал/	1	200,000	200,000
6	Тавдугаар байр /мөнгөн шагнал/	1	150,000	150,000
7	Тусгай байр /мөнгөн шагнал/	3	100,000	300,000
8	Өргөмжлөл	8	30,000	240,000
9	Мандат	40ш	3,000	120,000
10	Шүүгчийн замын зардал	2	49,600	198,400
11	Шүүгчийн урамшуулал	2	100,000	200,000
12	Буудлын зардал	1өрөө, 2 хоног	120,000	240,000
13	Цайны зардал	45	15,000	675,000
14	Анонс	1 /5x6/	450,000	450,000
15	Бичгийн цаас	1 боодол	26,600	26,600
		Нийт дүн		5,000,000